

Өлгий сумын ЗДТГ-ын 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл

- Сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг болон бусад холбогдох төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч, ня-бо нарт уулзалт, сургалт зохион байгуулав.
- Байгууллагуудын сарын санхүүжилтийн мэдээг хүлээн авч нэгтгэн аймгийн Төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
- Төрийн захиргааны хуулийг хэрэгжүүлэх сургалтанд ИТХ-ын дарга, ЗД, ЗДТГ-ын дарга, хууль эрх зүйн ажилтан, газрын даамал зэрэг албан тушаалтнууд хамрагдан сургалтанд оролцов.
- Гэр хороололын алслагдсан хэсэгт шинээр газар эзэмшсэн айл өрхүүдэд гүний худаг гаргах судалгааг гаргав.
- Тамхи худалдах улсын тэмдэгтийн хураамж төлсөн 3 ш хүнсний дэлгүүрт тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож, хураамжыг орон нутгийн татварын дансанд оруулсан.
- Гамшгаас хамгаалах команд штабын сургалтыг баг тус бүрээс иргэдийн төлөөллийг оролцуулсан Онцгой байдлын хэлтэстэй хамтран иргэний танхимд зохион байгуулав.
- Стадионы засвар тохижилт, замын тэмдэг тэмдэглэгээний зураг, төсвийг хийлгэн бэлэн болгосон.
- Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагуудаас ард иргэдэд хууль, сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгийг төв талбайд зохион байгуулав.
- Хотын төв хэсгийн байгууллагуудаар явж орчноо тохижуулах, барилгаа засварлаж өнгө үзэмжийг сайжруулах талаар санал, зөвлөгөө өгч, мэдэгдэл хүргэж ажиллав.
- Ногоон байгууламжийн хашааны тохижилтыг сайжруулах талаар аймгаас байгуулсан комисстой хамтарч судалгаа хийж, зураг төсөл зохиох ажлыг эхэлж байна.
- Өлгий сумын Засаг дарга, БОАЖ-ын газрын дарга нараар батлуулсан хяналт шалгалтын ажлын удирдамжын дагуу “Эрчим-Баян” ХХК, “Тэнгэр-Алтай-Тоосго” ХХК, “Ахниет” халуун ус, “Балбал-Тас” чулууны үйлдвэр, “Гүлим” халуун ус, Арвин зоогийн газруудад хяналтын хуудас бичиж, үйл ажиллагаанд шалгалтанд хамруулав.
- Аймгийн МХГ-ын даргаар батлуулсан урьдчилан сэргийлэх ажлын удирдамж, хувиарын дагуу 2 удаа 24 цаг эргүүлд гарч хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллав.
- 0340 дүгээр ХЦ ангид гэрээ хийж 35.000 төгрөгийн хураамжыг Өлгий сумын Төрийн санд оруулав.
- Орон нутгийн “Дербес” телевизээр Усны тухай хуулийн талаар ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийв.
- Ногоон бүсийн хашаануудын услах ажлыг хийж байна.
- Захиалгаар явж бш нохой буудав.
- Гудамж, зам дагуу олон нийтийн газруудад бүгд 245ш хайлаас мод суулгаж услах ажил хийж байна.
- Бүх нийтээр мод тарих өдрийн бэлтгэл ажил хийж бууц буулгах ажил хийж байна.